ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн төв номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/216/СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улиастай сум<br>2022 он | Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа<br>Утас: 99993365<br>Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn<br><br>Аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч : Г.Заяа<br>Утас:92038288<br>Цахим хаяг:zayag@audit.gov.mn<br><br>Интер аудит ХХК<br>Гэрээт аудитор: Г.Алтанцэцэг<br>Утас: 99469299, 90111091<br>Цахим хаяг: altan_fin@yahoo.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт ........................................ 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........................................ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........................................ 6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........................................ 7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........................................ 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........................................ 10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........................................ 11
3. Аудитын тайлан ........................................ 12
3.1 Ерөнхий зүйл ........................................ 12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........................................ 12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................ 12
3.4 Материаллаг байдал ........................................ 13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........................................ 13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........................................ 14
3.6.1 Төсвийн төлөвлөлт ........................................ 14
3.6.2 Төсвийн гүйцэтгэл ........................................ 14
3.6.3 Нэмэлт төсөв ........................................ 14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........................................ 14
3.8 Аудитын гол асуудал ........................................ 14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........................................ 14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........................................ 14
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ........................................ 14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................ 15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................ 15
4. Аудитын илрүүлэлт ........................................ 15
4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит ........................................ 15
4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит ........................................ 15
4.2.1 Залруулсан алдаа ........................................ 15
4.2.2 Төлбөрийн акт ........................................ 15
4.2.3 Албан шаардлага ........................................ 15
4.2.4 Зөвлөмж өгөгдөөгүй ........................................ 15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........................................ 16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |

## 1.Аудитын санал дүгнэлт

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022.02.21 № 1302/92

танай ____ -ны № ____ -т

ТӨВ НОМЫН САНГИЙН
ДАРГА Ж.ДОРЖХАНД-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

01302?057

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **9,569.55** | **6,218.79** |
| **33** | **АВЛАГА** | 200.00 | - |
| **335** | **Бусад авлага** | 200.00 | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 200.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 9,369.55 | 6,218.79 |
| **354** | **Хангамжийн материал** | 9,369.55 | 6,218.79 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,006.50 | 523.50 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,836.35 | 5,633.79 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 61002E50 | 61.50 |
| 35450 | Барилгын засварын материал | 2,465.20 | - |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **250,219.72** | **246,260.76** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 250,219.72 | 246,260.76 |
| **392** | **Биет хөрөнгө** | 241,287.72 | 237,504.76 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 109,171.01 | 109,171.01 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (14,300.85) | (21,451.28) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 21,400.00 | 21,400.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (21,400.00) | (21,400.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 25,872.73 | 30,872.73 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (17,601.81) | (19,788.35) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 30,482.49 | 30,682.49 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (18,531.95) | (21,331.24) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 4,351.00 | 4,351.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,444.63) | (1,879.73) |
| 39217 | Ном | 123,289.74 | 126,878.14 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 8,932.00 | 8,756.00 |
| 39301 | Програм хангамж | 3,589.65 | 3,589.65 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (3,237.65) | (3,413.65) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 8,580.00 | 8,580.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **259,789.27** | **252,479.55** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **229.66** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 229.66 | - |
| **413** | **Өглөг** | 229.66 | - |
| **4136** | **Бусад өглөг** | 229.66 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 229.66 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **259,559.61** | **252,479.55** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 259,559.61 | 252,479.55 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 474,090.70 | 474,090.70 |
| 51101 | Өмч: - төрийн | 474,090.70 | 474,090.70 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (251,921.19) | (259,001.26) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (251,921.19) | (251,921.19) |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (7,080.06) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 37,390.11 | 37,390.11 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **259,789.27** | **252,479.55** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **186,483.25** | **181,236.70** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **12,945.05** | **915.50** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 12,945.05 | 915.50 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 12,944.55 | 915.50 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 145.00 | 53.50 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 12,799.55 | 862.00 |
| 120009 | Бусад орлого | 0.50 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **173,538.20** | **180,321.20** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 173,393.20 | 173,393.20 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 173,393.20 | 173,393.20 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 145.00 | 6,928.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 5,678.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 1,250.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 145.00 | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **184,546.74** | **188,316.76** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **184,546.74** | **188,316.76** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 183,458.97 | 187,812.27 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 124,905.28 | 123,595.70 |
| 210101 | Үндсэн цалин | 97,079.91 | 89,210.34 |
| 210102 | Нэмэгдэл | 22,610.41 | 30,006.69 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,214.97 | 4,378.67 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 16,658.50 | 16,649.77 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,305.71 | 11,605.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,013.92 | 1,194.77 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,355.64 | 1,023.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 733.42 | 370.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,249.82 | 2,457.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,827.26 | 23,367.90 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 954.91 | 890.93 |
| 210302 | Түлш, халаалт | 20,532.42 | 22,232.49 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 339.93 | 244.48 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,709.01 | 5,142.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,164.50 | 1,207.25 |

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 386.20 | 386.20 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 402.20 | 419.49 |
| 210404 | Ном, хэвлэл | 55.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 385.60 | 417.70 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,315.51 | 2,711.86 |
| **2105** | **Нормативт зардал** | 10.70 | 210.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10.70 | 210.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,649.70 | 729.60 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 250.00 | 299.50 |
| 210604 | Урсгал засвар | 2,399.70 | 430.10 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 75.00 | 454.40 |
| 210702 | Дотоод албан томилолт | 75.00 | 454.40 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,393.27 | 2,353.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 183.80 | 432.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 104.47 | 79.50 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80.50 | 80.50 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,772.80 | 1,761.00 |
| 210807 | Газрын төлбөр | 8.90 | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 242.80 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11,230.25 | 15,309.39 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 215.00 | 1,626.63 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 355.00 | 935.40 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 10,660.25 | 12,747.36 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,087.77 | 504.50 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 500.00 | 499.90 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500.00 | 499.90 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 587.77 | 4.60 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 587.77 | 4.60 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,936.52** | **(7,080.06)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,936.52** | **(7,080.06)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 462,420.18 | - | (247,712.90) | 214,707.27 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **462,420.18** | **-** | **(247,712.90)** | 214,707.27 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 3,667.54 | 3,667.54 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **474,090.70** | **37,390.11** | **(251,921.19)** | 259,559.61 |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **474,090.70** | **37,390.11** | **(251,921.19)** | 259,559.61 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **474,090.70** | **37,390.11** | **(251,921.19)** | 259,559.61 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (7,080.06) | (7,080.06) |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **474,090.70** | **37,390.11** | **(259,001.26)** | 252,479.55 |

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **173,683.70** | **180,374.70** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **145.50** | **53.50** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 145.50 | 53.50 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 145.00 | 53.50 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 145.00 | 53.50 |
| 120009 | Бусад орлого | 0.50 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **173,538.20** | **180,321.20** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 173,393.20 | 173,393.20 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 173,393.20 | 173,393.20 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 145.00 | 6,928.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 5,678.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 1,250.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 145.00 | - |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **170,874.50** | **172,448.30** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **170,874.50** | **172,448.30** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **169,786.73** | **171,943.70** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 123,339.26 | 123,395.70 |
| 210101 | Үндсэн цалин | 95,513.89 | 89,010.34 |
| 210102 | Нэмэгдэл | 22,610.41 | 30,006.69 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,214.97 | 4,378.67 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 16,658.50 | 16,649.77 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,305.71 | 11,605.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,013.92 | 1,194.77 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,355.64 | 1,023.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 739.39 | 370.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,243.85 | 2,457.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,597.60 | 23,597.56 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 954.91 | 890.93 |
| 210302 | Түлш, халаалт | 20,302.76 | 22,462.15 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 339.93 | 244.48 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,212.50 | 2,174.54 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 1,199.50 | 1,199.25 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 386.20 | 386.20 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 402.20 | 419.49 |
| 210404 | Ном, хэвлэл | 55.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 169.60 | 169.60 |
| **2105** | **Нормативт зардал** | 290.90 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 290.90 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,649.70 | 699.70 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 250.00 | 300.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,399.70 | 399.70 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 75.00 | 454.40 |
| 210702 | Дотоод албан томилолт | 75.00 | 454.40 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,393.27 | 2,353.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 183.80 | 432.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 104.47 | 79.50 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80.50 | 80.50 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,772.80 | 1,761.00 |
| 210807 | Газрын төлбөр | 8.90 | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 242.80 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 570.00 | 2,619.03 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 215.00 | 1,683.63 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 355.00 | 935.40 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,087.77** | **504.60** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 500.00 | 500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500.00 | 500.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 587.77 | 4.60 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 587.77 | 4.60 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **2,809.20** | **7,926.40** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **2,809.20** | **7,926.40** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,809.20** | **7,926.40** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,809.20 | 7,926.40 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,809.20 | 7,926.40 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(2,809.20)** | **(7,926.40)** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 173,393.20 | 173,683.20 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 173,393.20 | 173,683.20 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 172,893.20 | 173,179.57 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 123,395.70 | 123,395.70 |
| 210101 | Үндсэн цалин | 94,169.00 | 89,010.34 |
| 210102 | Нэмэгдэл | 21,666.70 | 30,006.69 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,560.00 | 4,378.67 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 16,658.50 | 16,649.77 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11,722.60 | 11,605.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,234.00 | 1,194.77 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 987.20 | 1,023.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 246.80 | 370.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,467.90 | 2,457.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,597.60 | 23,597.56 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,054.30 | 890.93 |
| 210302 | Түлш, халаалт | 21,499.20 | 22,462.15 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,044.10 | 244.48 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,041.70 | 5,116.54 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,199.50 | 1,199.25 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 386.20 | 386.20 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 419.40 | 494.49 |
| 210404 | Ном, хэвлэл | 2,867.00 | 2,867.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 169.60 | 169.60 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 699.70 | 699.70 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 300.00 | 300.00 |
| 210604 | Урсгал засвар | 399.70 | 399.70 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 454.40 | 454.40 |
| 210702 | Дотоод албан томилолт | 454.40 | 454.40 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,347.70 | 2,353.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 306.00 | 432.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 79.50 | 79.50 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 80.50 | 80.50 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,772.80 | 1,761.00 |
| 210807 | Газрын төлбөр | 108.90 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 697.90 | 912.90 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 215.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 697.90 | 697.90 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 500.00 | 503.63 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 500.00 | 500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500.00 | 500.00 |
| | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 3.63 |
| | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | - | 3.63 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 173,683.20 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | 173,538.20 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | - | 173,538.20 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | 145.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 145.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 0.011 | 0.011 |
| 620001 | Удирдах ажилтан | 0.001 | 0.001 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 0.009 | 0.009 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 0.001 | 0.001 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **6,981.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,981.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 6,980.53 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,980.53 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,743.03 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 237.50 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 0.97 |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 0.97 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **6,981.50** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 6,981.50 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,678.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,250.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 53.50 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Завхан аймгийн төв номын сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллага нягтлан бодох бүртгэл,тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Интер аудит ХХК-ийн гэрээт аудитор Г.Алтанцэцэг, Интер Аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Мөнхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитын менежерийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Заяа, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн төв номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 11-ны өдрийн №09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Завхан аймгийн төв номын сан нь уламжлалт номын сангийн үйлчилгээг орчин үеийн стандарттай хослуулан иргэдэд тэгш хүртээмжтэй үйлчлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага нь боловсролын системийн байгууллагад дагаж мөрддөг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа дагаж мөрддөг, дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн төв номын сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 173.4 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 2.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлыг 75 хувь буюу 1.95 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 200.00 | - | (200.00) |
| Бараа материал | 9,369.55 | 6,218.79 | (3,150.76) |
| Үндсэн хөрөнгө | 250,219.72 | 246,260.76 | (3,958.96) |
| **Нийт хөрөнгө** | **259,789.27** | **252,479.55** | **(7,309.72)** |
| Өр төлбөр | 229.66 | - | (229.66) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 259,559.61 | 252,479.55 | (7,080.06) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **259,789.27** | **252,479.55** | **(7,309.72)** |

Авлага дансны үлдэгдэл 0.2 сая төгрөгөөр буурсан нь хувь хүмүүсээс авах авлага нь барагдсантай холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 3.1 сая төгрөгөөр буурсан нь 4.9 сая төгрөгөөр нэмэгдэж, 2.7 сая төгрөгийн бараа материал актлан, 5.3 сая төгрөгийн бараа материал зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3.9 сая төгрөгөөр буурсан нь 8.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө Засаг даргын нөөц сангаас олгогдож, 12.7 сая төгрөгийн элэгдлийн зардал хасагдсантай холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 0.2 сая төгрөгөөр буурсан нь өмнөх оны өр төлбөрөө барагдуулсантай холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 173.4 сая төгрөгөөр, нийт зарлагыг 173.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 173.6 сая төгрөгийн, туслах үйл ажиллагааны орлогоос 0.145 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 173.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Нэмэлт төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 6.93 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 0.05 сая төгрөг, нийт 6.98 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд 6.98 сая төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Нягтлан бодогч нь  худалдан авалт хийхдээ и баримтыг  бүрэн бүрдүүлээгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2021 онд нийт 147 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 137 мэдээг хугацаанд, 10 мэдээллийг хугацаа хоцроож  байршуулсан байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар зөрчилгүй санал дүгнэлт өгсөн бөгөөд бараа материалын дансанд хөрөнгийн шинжтэй зүйлс байсныг аудитын өгсөн зөвлөмжийн дагуу данс хооронд шилжүүлэн залруулж тайлагнасан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

## 4. Аудитын илрүүлэлт

### 4.1 Засварын үеийн санхүүгийн тайлангийн аудит

Завсрын үеийн аудитад хамрагдаагүй байна.

### 4.2 Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит

Аудитаар нийт 1.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлсэн.

#### 4.2.1 Залруулсан алдаа

Залруулга хийгдээгүй.

#### 4.2.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

#### 4.2.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй.

#### 4.2.4 Зөвлөмж өгөгдөөгүй

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*<u>Илрүүлэлт:</u>*

- ✓ *1.4 сая төгрөгийн зардлын анхан шатны баримт /и-баримт/-ыг бүрэн бүрдүүлээгүй;*

*<u>Өгсөн зөвлөмж</u>:*

- ✓ *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"; Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ."; Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ."; гэж заасныг хэрэгжүүлж ажиллах*

- ✓ *Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Санхүүгийн тайлангийн аудитын асуудал** | | | | | | | | | | | |
| | Завхан аймгийн төв номын сан | 1 | 1.4 | | | | | | | 1 | 1.4 |
| **Дүн** | | **1** | **1.4** | | | | | | | **1** | **1.4** |